

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ
ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨР

ХЭРВЭЭ ТА

АЖИЛГҮЙ
ИРГЭН

АЖИЛ
ОЛОХОД
ХҮНДРЭЛТЭЙ
ИРГЭН

АЖИЛГҮЙДЭЛД
ӨРТӨЖ
БОЛЗОШГҮЙ
ИРГЭН БОЛ



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ЦОГЦ СУРГАЛТАД
БҮРТГҮҮЛЭЭРЭЙ**

ЦОГЦ СУРГАЛТАД ХЭН ХАМРАГДАХ ВЭ?

Хэрэв та дараах шалгуурыг хангаж байвал хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтад хамрагдах хүсэлтээ гаргах боломжтой:

- 18 насанд хүрсэн
- Бичиг үсэг тайлагдсан
- Дүүрэгтээ байнгын болон түр оршин суугчийн бүртгэлтэй
- Урт хугацааны сургалтад хамрагдах боломжтой

ЦОГЦ СУРГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт нь дараах бүрэлдэхүүнтэй. Сургалт 2019 оны 12 сард эхлэх бөгөөд таны сонгосон мэргэжлээс хамаарч нийтдээ 16-20 долоо хоног үргэлжилнэ.

1. МОДУЛЬТ СУРГАЛТ



Хандлага, төлөвшил,
харилцааны ур
чадварын сургалт
(5 өдөр: 32 цаг)



Компьютер, цахим
орчны сургалт
(5 өдөр: 32 цаг)



Хувь хүний санхүүгийн
мэдлэг, чадварыг
дээшлүүлэх сургалт
(3 өдөр: 18 цаг)

2. МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ: 7-9 ДОЛОО ХОНОГ

Та дараах 8 мэргэжлээс сонгон суралцах боломжтой. Мэргэжлийн сургалтын хувьд онол 30%, дадлага 70% гэсэн харьцаатай байна. Хичээл долоо хоногт 36 цагаас багагүй байна.

Барилгын
цахилгаанчин
(8 долоо хоног)



Барилгын засал
чимэглэлчин
(7 долоо хоног)



Оёмол бүтээгдэхүүний
оёдолчин
(9 долоо хоног)



Мах боловсруулах
үйлдвэрлэлийн
ажилтан
(8 долоо хоног)



Сүү боловсруулах
үйлдвэрлэлийн
ажилтан
(7 долоо хоног)




Арьс, шир боловс-
руулалтын технологийн
ажилтан
(7 долоо хоног)



Эсгий, ноос, ноолуур боловсруулах
анхан шатны технологийн ажилтан
(9 долоо хоног)



Зочид буудлын
өрөөний үйлчлэгч
(8 долоо хоног)



3. АЖЛЫН БАЙРАН ДЭЭРХ ДАДЛАГА: 7-8 ДОЛОО ХОНОГ

№	Мэргэжлийн чиглэл	Дадлагын долоо хоног
1.	Барилгын цахилгаанчин	7
2.	Барилгын засал чимэглэлчин	7
3.	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	8
4.	Мах боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	7
5.	Сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	7
6.	Арьс шир боловсруулалтын технологийн ажилтан	7
7.	Эсгий, ноос, ноолуур боловсруулах анхан шатны технологийн ажилтан	8
8.	Зочид буудлын өрөөний үйлчлэгч	7

4. АЖИЛ ХАЙХ УР ЧАДВАРЫН СУРГАЛТ: 2 ӨДӨР

5. СУРГАЛТЫН ДАРААХ ДЭМЖЛЭГ: 3 САР

Ажил хайх ур чадварыг сайжруулах, ажил эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулах, ажлын байранд зуучлах үйлчилгээ болон гар утасны дуут мессежээр хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг бататгах мэдээлэл хүргэнэ.

6. ЧАДАМЖИЙН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

Төгсөгчид хөндлөнгийн үнэлгээнд хамрагдаж, чадамжийн гэрчилгээ авна.

ЦОГЦ СУРГАЛТЫН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ

- Тухайн мэргэшлийн II түвшний чадамжийг бүрэн эзэмшинэ.
- Ажил эрхлэхэд шаардагдах цогц ур чадварт суралцана.
- Сургалтын бүх зардлыг төрөөс хариуцна. Зөвхөн чадамжийн гэрчилгээний үнэ 10 000 төгрөгийг суралцагч төлнө.
- Сургалт, дадлагын хугацаанд хоол, унааны зардлын хөнгөлөлт өдрийн 5 000 төгрөг олгоно.

СУРГАЛТАД ХАМРАГДАХЫН ӨМНӨ АНХААРАХ ЗҮЙЛ

- Та суралцах мэргэжлийн чиглэлээ сонгохдоо дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнээс зөвлөгөө аваарай.
- Та 1-3 мэргэжлийн чиглэл сонгож болно.
- Сургах хүний тоо хэтэрсэн тохиолдолд санамсаргүй түүврийн аргаар суралцагчийг сонгох магадлалтай.

СУРГАЛТАД ХАМРАГДАХ ХҮСЭЛТЭЙ ИРГЭНИЙ БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД



ИРГЭНИЙ ЦАХИМ ҮНЭМЛЭХ



ЦОГЦ СУРГАЛТАД ХАМРАГДАХ ИРГЭНИЙ ХҮСЭЛТ

(Харьяа дүүргийн ХХҮХ-ээс эсвэл Дүнжингарав дахь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөс авна)



ТҮР ОРШИН СУУГЧ БОЛ ХАРЬЯАЛАГДАХ ХОРООНООС АВСАН ТОДОРХОЙЛОЛТ

(Түр оршин сууж эхэлсэн огноог оруулсан байна)

Хэрэв та “ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЦОГЦ СУРГАЛТ”-д суралцахыг хүсвэл 2019 оны 11 сарын 25-ныг хүртэл харьяа дүүргийн ХХҮХ эсвэл Дүнжингарав дахь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд өөрийн биеэр ирж бүртгүүлээрэй.